



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/693

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Сая хүч” ХХК-ий хийж гүйцэтгэсэн Жаргалант сумын Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэнгийн 5 усан оргилуурын засварын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Тогтохбаяр

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэд бүтэц хариуцсан гэрээт ажилтан

Н.Ганбат

- “Мянган угалзат” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга

Ц.Даваасамбуу

- Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

С.Батдорж

- Аймгийн архивын тасгийн дарга

Б.Бархүү

- “Сая хүч” ХХК-ний захирал

Нарийн бичгийн
дарга: С.Өнөржаргал

-Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. “Сая хүч” ХХК-ий хийж гүйцэтгэсэн ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн дотор багтаан захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Тогтохбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН